

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 03

Өлгий хот

“Эрчимбаян өлгий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 16:30 цагаас компанийн хурлын танхимд хуралдуулж, хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Манен удирдав.

Тус хуралд нийт 536 177 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааны 421 148 ширхэг буюу 78.5 хувийг эзэмшигч Д.Мурат, 75 800 ширхэг буюу 14.13 хувийг эзэмшигч М.Тилеуберди нар болон компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Манен, гишүүд А.Бейбит, У.Харашаш, Ц.Баттөмөр, Х.Адалбек, хараат бус гишүүд А.Мубарак Х.Ертай, Е.Жанболат болон санхүүгийн ажилтнууд оролцов.

Хурлын тооллогын комиссын мэдээллийг комиссын дарга О.Адилбек танилцуулав.

Хуралд компанийн дүрмийн 7.4 дэх хэсэгт заасны дагуу нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 92.63 хувь нь оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2025 оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг (хараат бус аудиторын дүгнэлтийн хамт) танилцуулах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх тухай
4. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн мэдээллийг хэлэлцэж батлах;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг нэмэгдүүлэх тухай тус тус хэлэлцэх болно.

А.МАНЕН: Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай тогтоолоор товлогдсон өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэж, хурал эхэлснийг мэдэгдье. Тус хурлаар хэлэлцэх эхний асуудал бол компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцье. Холбогдох хүмүүс танилцуулна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг А.Бейбит гишүүн танилцуулав.

Дараа нь хуралд оролцогчид саналаа хэлэв.

А.БЕЙБИТ: Манай компани тус аймгийн Өлгий сумын төв талбайн газар доорх магистраль буюу 500-ийн голчтой 400-ийн шугамд өөрийн 100 хувийн хөрөнгөөр өргөтгөлийн ажлыг хийж, ашиглалтад оруулсан. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд Голомт банкнаас 1,5 тэрбум зээл авч гүйцэтгэсэн. Үүнээс болж компанийн ашиг энэ жил бага гарсан.

М.ТИЛЕУБЕРДИ: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлттэй бүрэн танилцсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 132, 236 дугаар тогтоолоор 2025–2026 онд аливаа төлбөр, хураамжийг нэмэгдүүлэхийг хойшлуулсантай холбогдуулан, мөн он гарснаас хойш төсөвт байгууллагуудын халаалтын төлбөр төлөгдөөгүйгээс болж компанийн орлогын эх үүсвэр хумигдаж, мөнгөн хөрөнгийн дутагдал үүсэж, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүрээд байна. Түүнчлэн аймгийн Цахилгаан шугам сүлжээний газарт төлөх цахилгаан эрчим хүч ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлж чадаагүйгээс болж их хэмжээний авлага хуримтлагдаж цахилгааныг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ үүсэж байна.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар нууцаар санал хурааж саналыг тоолоход саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: Компанийн 2025 оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг (хараат бус аудиторын дүгнэлтийн хамт) танилцуулах;

А.МАНЕН: Энэ талаар тус байгууллагын Ерөнхий нягтлан бодогч К.Ерболат танилцуулъя.

К.ЕРБОЛАТ: Энэ жил “Эрчимбаян өлгий” ХК нь “Солид Юнити Аудит” ХХК-ийн хооронд 2025 оны А/26/10 дугаартай “Аудитын үйлчилгээ үзүүлэх тухай” гэрээ байгуулж, 2025 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж, хараат бус аудитын тайланг гаргаж өгсөн болно. Байгууллагын зүгээс ямар нэг зөрчил дутагдал илрээгүй болно.

Д.МУРАТ: Манай компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Солид Юнити Аудит” ХХК-иар аудитын тайланг хууль журмын дагуу гаргаж байгаа юм байна.

К.ЕРБОЛАТ: Аудитын тайлан их нарийвчлалтай гарсан.

Хуралд оролцогчдоос өөр санал гараагүй тул хувьцаа эзэмшигчдийн 100 хувь дэмжсэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Компанийн 2025 оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг батлав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх тухай

У.ХАРАШАШ: Миний зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох саналтай байна. Даргаар нь А.Манен гуай, гишүүдээр А.Бейбит, У.Харашаш,

Ц.Баттөмөр, нарийн бичгийн дарга О.Адалбек, харин хараат бус гишүүд нь А.Мубарак, Х.Ертай, Е.Жанболат нар байхаар. Та бүхэн саналаа хэлнэ үү.

А.БЕЙБИТ: Би санал нэгтэй байна.

А.МУБАРАК: Миний зүгээс татгалзах зүйлгүй.

Гишүүдээс өөр санал гаргасан хүнгүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улиран сонгохоор оруулсан саналын дагуу 100% - иар санал нэгтэй дэмжигдэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улираан сонгох

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4: Компанийн ноогдол ашиг хуваарилахгүй талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;

У.ХАРАШАШ: Тус компани нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар -638,239,577.27 төгрөгийн алдагдалтай гарсан боловч 915,423,248.74 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 103,195,385.88 төгрөгийн, банкнаас авсан богино хугацаат зээл 795,993,571.80 төгрөг ба урт хугацааны 3,778,721,937.44 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан шаардлагыг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

А.МАНЕН: Засгийн газрын 2025 онд батлагдсан 132, 236 дугаар тогтоолоор 2025–2026 онд аливаа төлбөр, хураамжийг нэмэгдүүлэхийг хориглосон тул бид 2023 онд батлагдсан дулааны тарифыг одоог хүртэл мөрдөж ажиллаж байна. Энэ нь манай компанид маш их алдагдал учруулж байна. Үүнээс болж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байх талаар тогтоолыг баталсан. Хуульд зааснаар энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэх ёстой.

Ногдол ашиг хуваарилахгүй байх тогтоолын төслийг батлах асуудлаар санал хураахад хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг санал нэгтэй дэмжиж батлах

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5: Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг нэмэгдүүлэх тухай

К.ЕРБОЛАТ: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд сар бүр мөнгөн урамшуулал олгох нь зүйтэй байх.

М.ТИЛЕУБЕРДИ: Манай байгууллага одоогоор санхүүгийн боломж муутай байгаа. Гэсэн хэдий ч бид ажилчдын цалин хөлсийг тогтмол олгож байна. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд жилд нэг удаа 2,000,000 төгрөгийн урамшуулал олгож болно.

У.ХАРАШАШ: Та бүхэн санхүүгийнхээ боломж бололцоогоороо жилд нэг удаа мөнгөн урамшуулал олгож болно гэж миний зүгээс үзэж байна. Би дэмжиж байна.

А.БЕЙБИТ: Би бас дэмжиж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг нэмэгдүүлэх тухай асуудлаар санал хураахад хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг нэмэгдүүлэх тухай шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг санал нэгтэй дэмжиж батлах.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *О. Адалбек* О.АДАЛБЕК

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:
ХУРЛЫН ДАРГА *А. Манен* А.МАНЕН

